

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)-ийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны журам (“Журам”)-ыг Компани болон түүний охин компанийн үйл ажиллагаанд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэн явуулах ерөнхий зарчим, стандартыг тогтооход оршино.

1.2. Хамрах хүрээ

Компани болон түүний охин компанийн нийт ажилтан энэхүү Журмыг дагаж мөрдөнө.

1.3. Хяналт, нэмэлт өөрчлөлт

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо тухай бүр, шаардлагатай хэмээн үзсэн үедээ энэхүү Журам болон түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ТУЗ-д танилцуулах ба аливаа өөрчлөлтийг ТУЗ баталснаар хүчин төгөлдөр мөрдөнө.

1.4. Журмын нөхцөл

Энэхүү Журам болон Компанийн Дүрмийн хооронд зөрчил үүссэн тохиолдолд Компанийн Дүрэм давуу хүчинтэй байх ба энэ Журам нь Монгол Улсын хууль, тогтоомжтой нийцээгүй тохиолдолд сүүлд батлагдсан хуулийн зохицуулалт нь давуу хүчинтэй байна. Энэхүү Журмын заалтыг хэрхэн тайлбарлах болон тэдгээрийг хэрэглэхтэй холбогдсон зарим тодорхойгүй байдал, санал зөрөлдөөн үүссэн үед бусад ТУЗ-ийн гишүүдийн оролцоотойгоор ТУЗ-ийн даргын саналаар шийдвэрлэнэ. Энэ Журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Компанийн Дүрэм болон бусад эрх зүйн актад зааснаар шийдвэрлэнэ.

1.5. Нэр томьёо

Энэхүү журамд хэрэглэсэн зарим нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.5.1. “**мөнгө угаах**” гэж аливаа орлого, эд хөрөнгийг хууль бусаар олсон гэдгийг урьдчилан мэдсээр байж, түүний эх үүсвэр, гарал үүслийг нуун далдалж уг орлого, эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор түүнийг гүйлгээнд оруулахыг;

1.5.2. “**терроризмыг санхүүжүүлэх**” гэж террорист байгууллага болон террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж, аливаа хэлбэрээр эд хөрөнгө хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулахыг.

2. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд Компани нь дараах үйл ажиллагаанаас татгалзана:

2.1.1. Гарал үүсэл нь тодорхойгүй мөнгийг ашиглах, өмчлөх, зарцуулах;

2.1.2. Террорист байгууллага болон террорист үйл ажиллагаанд ашиглагдахыг мэдсээр байж эд хөрөнгө олж авах, шилжүүлэх захиран зарцуулах;

2.1.3. Бусад хууль бус үйл ажиллагаа явуулах.

3. КОМПАНИЙН ҮҮРЭГ

- 3.1. Компани нь гэрээлэгч этгээдийн нэр, хаяг, эрх зүйн статус, гэрээ байгуулах чадвар, чадамжтай эсэх талаар холбогдох мэдээллийг авалгүйгээр тухайн иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулахгүй, гэрээний дагуу төлбөр шилжүүлэхгүй.
- 3.2. Компани нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар санал, санаачлаг гаргасан гэрээлэгчтэй хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.
- 3.3. Компанийн Санхүүгийн газар нь 100,000,000 (нэг зуун сая) төгрөгөөс дээш үнийн дүнтэй аливаа гүйлгээг хүлээн авах үед анхаарал хандуулж ажиллах ба тухайн гэрээлэгчээс шилжүүлж буй мөнгөний гарал үүслийн тодруулга шаардан гаргуулна. Хэрэв гэрээлэгч Компаниас шилжүүлэх мөнгөний гарал үүслийн талаар тодруулахыг хүсвэл Компани нь уг мэдээллийг гаргаж өгнө.
- 3.4. Санхүүгийн газар нь Компанийн ажиллагсдыг мөнгө угаах, терроризм, бусад хууль бус үйл ажиллагаанд холбогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлж, үүнээс гарч болох үр дагаврын талаар мэдээлэл сурталчилгаа зохион байгуулна.
- 3.5. Санхүүгийн газар нь мөнгөний гарал үүсэл нь гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй гэсэн сэжиг илэрвэл хууль тогтоомжид заасны дагуу шаардлагатай мэдээллийг төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх, мэдээ мэдээлэл олж авах нөхцөлөөр хангах, тэдгээрээс мэдээлэл олж авах зэргээр хамтран ажиллана.
- 3.6. Компани нь мөнгө угаах нөхцөл боломжийг бүрдүүлэх, өөрийн ажиллагсдыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, террорист үйл ажиллагаа, авлига, бусад хууль бус үйл ажиллагаанд холбогдохоос урьдчилан сэргийлэх талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна.

4. БУСАД

- 4.1. Энэхүү Журмын хэрэгжилтэд Компанийн Санхүүгийн газар, дотоод хяналтын нэгж хяналт тавьж ажиллана.
- 4.2. Энэхүү Журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.